

# Төслийн товчоон

ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

2017 оны 4-р сар

Хэрэгжүүлэгч:



**The Asia Foundation**

Improving Lives, Expanding Opportunities

**Swiss Agency for Development  
and Cooperation SDC**

**Швейцарийн хөгжлийн агентлаг**

## ХОТЫН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

### БАРИМТ МЭДЭЭЛЭЛ

#### Хөтөлбөрийн нэр

Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр

#### Төслийн нэр:

Хотын засаглалыг сайжруулах төсөл

#### Хугацаа:

07.2015-12.2018

#### Төсөв:

ШХА: 2,300,000 шв.франк

Азийн сан: 190,374 шв.франк

#### Зорилтот бүлэг:

- Нийслэл, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, хорооны Иргэдийн нийтийн хурал
- Хорооны албан хаагчид, төрийн захиргааны албан хаагчид
- Гэр хорооллын оршин суугчид

#### Зорилтот бүс нутаг:

Улаанбаатар хотын 9 дүүргийн гэр хорооллын 87 хороо



Улаанбаатар хотын гэр хорооллын иргэдийн хувьд нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж тулгамдсан асуудлын нэг юм.

### ОРШИЛ

Монгол Улс 1990 оноос хойш улс төр, нийгэм, эдийн засгийн томоохон өөрчлөлт, шинэчлэлийг хэрэгжүүлж байна. Эдийн засаг эрчимтэй хөгжсөн 2010-2014 онд ажил хөдөлмөр эрхлэх, амьдрал ахуйгаа сайжруулах боломж Улаанбаатарт илүү гэж үзсэн хөдөөгийн иргэд нийслэлд ихээр шилжин суурьшив. Хэдийгээр сүүлийн жилүүдэд эдийн засаг хүндэрсэн ч байдал өөрчлөгдсөнгүй, шилжин ирэгсдийн тоо жилээс жилд нэмэгдсээр өнөөдөр Монгол Улсын гурван сая гаруй иргэний талаас илүү хувь нь Улаанбаатарт амьдарч байна. Тэдний олонх нь дэд бүтэц муутай хотын захын гэр хороололд суурьшин, төлөвлөгдөөгүй суурьшлын бүсийг тэлсээр

ирсэн. Улмаар цэвэр ус, нэгдсэн халаалт, цахилгаан эрчим хүчний хангамж, бохир ус болон хог хаягдлын менежмент зэрэг суурь үйлчилгээг гэр хорооллын иргэдэд хүргэхэд хүндрэлтэй болоод байна. Хотын засаглалыг сайжруулах төсөл нь иргэдэд тулгамдсан асуудлын талаарх мэдээллийг бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад илүү хүргэх, хорооноос иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах болон хорооны ажилтнуудын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх замаар хотын оршин суугчдын амьжиргааг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулахыг зорьж байна.

### ШХА-ийн зорилго:

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахыг зорино.

### ТӨСЛИЙН ЗОРИЛТ:

Гэр хорооллын иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хөрөнгө оруулалт, төрийн үйлчилгээг төлөвлөн хүргэх нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх

### Иргэдийн санал хүсэлтийг шийдвэрт тусгахад дэмжлэг үзүүлэх

Хотын засаглалыг сайжруулах төсөл нь 2015 оноос хойш иргэдийн оролцоотой төсвийн төлөвлөлтийг дэмжин Орон Нутгийн Хөгжлийн Сан (ОНХС)-гийн хэлэлцүүлэгт иргэдийн бодит оролцоог нэмэгдүүлэхийг зорьж ирсэн. Төслийн хүрээнд ОНХС-ийн санхүүжилтээр бүх гэр хороодод хэрэгжсэн хөрөнгө оруулалтын газрын зураглалыг гаргахаас гадна тэнд амьдарч байгаа бага орлоготой өрх, нийгмийн бусад эмзэг бүлгийн суурьшил, нягтаршлыг харуулсан зорилтот бүлгийн зураглалыг хийнэ. Эдгээр зураглалуудыг тоо баримтад суурилсан, нийгмийн бүлэг бүрийн төлөөллийг хангасан төсвийн шийдвэр гаргахад ашиглахаар төлөвлөж байна. Мөн ОНХС-ийн санал асуулгыг цахимаар бөглөх боломж бүрдүүлж, иргэдийн ирүүлсэн саналыг нэгтгэн харах онлайн апплейкшн боловсруулснаар санал асуулгад оролцох иргэдийн тоог нэмэгдүүлж, тэдний саналыг шийдвэрт тусгах явцыг хялбарчилна. Түүнчлэн, ОНХС-аас гадна бусад асуудлаар иргэдээс ирж буй санал хүсэлт, мэдээллийг инфографик, хүснэгт зэрэгт хувиргах програм хангамж боловсруулснаар иргэдийн эрэлт хэрэгцээг тусгасан шийдвэр гаргах үйл явцыг дэмжинэ.

### Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг сайжруулах

Төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах НЗДТГ-аас дэвшүүлсэн зорилтыг дэмжих хүрээнд анхан шатны нэгж буюу хорооноос иргэдэд шинээр үзүүлж болох төрийн захиргааны гурван үйлчилгээг тодорхойлж, туршилтаар хэрэгжүүлнэ. Ингэхдээ ядуурлыг бууруулах, хүйсийн тэгш байдлыг хангахад нөлөөлөхүйц

үйлчилгээг сонгоход анхаарна. Улмаар үйлчилгээний шат дамжлагыг илүү оновчтой болгох аргачлал боловсруулсны үндсэн дээр сонгон авсан үйлчилгээний шат дамжлагыг хялбаршуулан сайжруулж, үйлчилгээг хорооноос хүргэхэд дэмжлэг үзүүлнэ. Ийнхүү туршсан аргачлалыг ашиглан НЗДТГ-аас төрийн захиргааны бусад үйлчилгээний шат дамжлагыг багасгаж, үйлчилгээг хорооноос хүргэх замаар иргэдэд илүү ойртуулах боломж бүрдэнэ. Үйлчилгээний шат дамжлагыг оновчтой болгож, анхан шатны нэгжээс үзүүлдэг болсноор үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааны үр ашиг, бүтээмж сайжрахын зэрэгцээ иргэдийн цаг зав, зардлыг хэмнэх ач холбогдолтой юм.

### Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх

Нийслэл, дүүрэг, хороодын төрийн захиргааны албан хаагчдын зүгээс иргэдэд мэргэжлийн түвшинд чанартай үйлчилгээ үзүүлэхэд нь шаардлагатай чадавхийг бэхжүүлэх чиглэлээр НЗДТГ-т дэмжлэг үзүүлнэ. Энэ хүрээнд НЗДТГ, Удирдлагын Академи болон холбогдох талуудтай хамтран төрийн албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлэх сургалтын тогтолцоог бий болгоно. Мөн иргэдтэй хамгийн ойр ажилладаг бүх 152 хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан, зохион байгуулагч, Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүд болон хэсгийн ахлагч нарт зориулсан сургалтыг НЗДТГ-тай хамтран санхүүжүүлэх замаар зохион байгуулна. Чадавх бэхжүүлэхэд чиглэсэн эдгээр бүх үйл ажиллагаа нь нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилготой юм.

### Хамтран хэрэгжүүлэгч түншүүд:

- Нийслэлийн Засаг даргын Тамгын Газар

### Холбоо барих:

#### Азийн сан Монгол

Ориент плаза, 3 давхар  
Г.Чагдаржавын гудамж-9  
Улаанбаатар, 14210, Монгол Улс

- +976 11 330524
- +976 11 311497
- mongolia.general@asiafoundation.org

### Швейцарийн ЭСЯ-ны Хамтын ажиллагааны газар

Монгол Улс, Улаанбаатар хот  
Элчингийн гудамж, 1-р хороо  
Скай Плаза Бизнес төв  
Ш/Х 37, Улаанбаатар 14210

- +976 11 331422
- +976 11 331420
- ulaanbaatar@eda.admin.ch
- www.swiss-cooperation.admin.ch/mongolia
- Swiss Cooperation in Mongolia



© Билли Макрае

Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн ажлуудыг газрын зураглал дээр буулгах ажлын үеэр Налайх дүүргийн 3 дугаар хорооны хэсгийн ахлагч нар өөрийн хэсгийн хил заагийг зурж байгаа нь.